



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 11 сарын 24 өдөр

Дугаар 404

Улаанбаатар хот

“Гантээрэм” ХК-ийн үнэт цаасыг
бүртгэлээс хасах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.10, Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйл, 2014 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 22 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Гантээрэм” ХК-ийн нийтэд санал болгон гаргасан нийт 296,504 /хоёр зуун ерэн зургаан мянга таван зуун дөрөв/ ширхэг хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасахыг Үнэт цаасны зохицуулалтын газар /Т.Гандулам/, хөрөнгийн биржийн жагсаалтаас хасахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /М.Болор/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хасахыг “ҮЦТТХТ” ХХК /Ж.Алдаржавхлан/-д тус тус үүрэг болгосугай.

2. Компанийн хэлбэрийг өөрчлөн хязгаарлагдмал хариуцлагатай компани болох шийдвэр гарсантай холбогдуулж өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдан авах үнийг 384,50 /гурван зуун наян дөрвөн төгрөг тавин мөнгө/ төгрөгөөр тооцон холбогдох арга хэмжээг Компанийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасан журмын дагуу зохион байгуулж, гүйцэтгэлийг ажлын 10 хоногт багтаан тус Хороонд тайлагнахыг “Гантээрэм” ХК /Г.Отгонбаяр/-д үүрэг болгосугай.

3. Шаардах эрхээ хэрэгжүүлээгүй хувьцаа эзэмшигч түүнд ногдох ногдол хувийн мөнгөн хөрөнгийг авалгүйгээр хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчээр үлдэх хүсэлтийг хэдийд ч гаргаж болох бөгөөд уг хүсэлтийг Компанийн тухай хуулийн 24.4-т заасан журмын дагуу өөрчлөн байгуулагдаж байгаа хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчээр бүртгэж авах үүргийг хэрэгжүүлэхийг “Гантээрэм” ХК /Г.Отгонбаяр /-д даалгасугай.

4. Энэ тогтоол батлагдсанаас хойш ажлын 10 хоногийн дотор Улсын бүртгэлийн ерөнхий газарт мэдээлэл хүргэхийг Үнэт цаасны зохицуулалтын газар /Т.Гандулам/-т, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б. Оюунцацрал/-т олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Л.Алтан-Од/-т тус тус даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

001072